Funded by the European Union
DW Akademie
MEDIA COUNCIL OF MONGOLIA
VOICES FOR CHANGE

№ 005 2026.10.31

МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

“Өөрчлөлтийн дуу хоолой” төсөл

Улаанбаатар хот
2026 он

Холбоо барих мэдээлэл:
Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 43-р хороо,
Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж,
Юу Би тауэр, 18-р давхар, #1803

Утас: (976) 7000 0160
И-мэйл: info@mediacouncil.mn
Вэбсайт: www.mediacouncil.mn

Facebook: V4C - Өөрчлөлтийн дуу хоолой **Instagram:** v4c_official

“ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ТҮНШЛЭЛ: ТӨР, ИРГЭНИЙ НИЙГМИЙН ТҮНШЛЭЛИЙГ БЭХЖҮҮЛЬЕ” ЧУУЛГАН БОЛЛОО

ИРГЭНИЙ НИЙГМИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

“Өөрчлөлтийн дуу хоолой” төсөл, Монголын залуучуудын эвсэлтэй хамтран 2026 оны 1 дүгээр сарын 30-нд иргэний нийгмийн өдрийг тохиолдуулан “Хөгжлийн төлөөх түншлэл: Төр, иргэний нийгмийн түншлэлийг бэхжүүлье” чуулган болж, хүний эрхийг хамгаалагч, идэвхтэн, хараат бус шинжээч болон төрийн бодлого боловсруулагч зэрэг 100 орчим хүн оролцлоо.





МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ УХНАГИЙН ХУРЭЛСҮХ ТАНАА

№ 24/06

2026 оны 2-р сарын 11-ний өдөр

“Хүчээгүй хуулийн тухай”

Чуулганыг харааг бус судлаач Ц.Батсугар “Төр – Иргэний нийгмийн түншлэлийг бэхжүүлэх нь: Иргэний орон зайн тулгамдсан асуудал” илтгэлээр эхлүүлсэн. Үүний дараа судлаач Д.Тэгшбаяр “Төрийн бус байгууллагын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, санал зөвлөмж” судалгааны дүгнэлтийг, мөн судлаач Д.Сүхжаргалмаа “Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлого” баримт бичгийн төслийг тус тус танилцуулав. “Төр ба иргэний нийгмийн түншлэлийг бэхжүүлэх нь: Иргэний орон зайн тулгамдсан асуудал” хэлэлцүүлгээр судлаачид, оролцогчид харилцан санал бодлоо солилцсон. Энэхүү хэсгийн илтгэлүүд, хэлэлцүүлгийн үр дүнд ИНБ-ууд хамтран чуулганы үеэр гарсан санал, олон талын байр суурийг тусган “Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийн төслийг эцэслэн боловсруулаа.

“Энэхүү баримт бичгийг баталснаар: Төр-иргэний нийгмийн түншлэлийн эрх зүйн орчин боловсронгуй болох; иргэдийн бодит оролцоо, хяналтын механизм бэхжих; иргэний нийгмийн байгууллагын тогтвортой, хараат бус үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлэх; цаашид Иргэний нийгмийн байгууллагын тухай хуулийн шинэчлэлийн суурь бүрдэх зэрэг бодит үр нөлөө гарах юм. Иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс дээрх бодлогыг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож, хамтран ажиллахаа үүгээр илэрхийлье.” хэмээн Иргэний нийгмийн консорциумаас Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхээс дэмжлэг үзүүлэхийг хүссэн захидлыг 2 дугаар сарын 11-нд хүргүүлсэн. Албан бичиг бүрэн эхээрээ: “Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичиг боловсруулжээ.

Чуулганы дараагийн нэг онцлох хэсэг бол цахиур илтгэлүүд байлаа. “Өөрчлөлтийн дуу хоолой”төслийнхүрээндиргэний нийгмийн байгууллагуудын зөвлөх үйлчилгээ, менторшип хөтөлбөрт оролцогч таван байгууллага

“Хөгжлийн төлөөх хариуцлага: Иргэний нийгмийн санаачилга”-ын хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, сайн туршлагаасаа хуваалцав. Байгууллагууд өөрсдийн туршлага, санал сэтгэгдлээ хуваалцсныг дараах холбоосоор хүлээн авна уу:



Хил хязгааргүй алхам төвийн Хөтөлбөрийн зохицуулагч Ч.Саранмандах: Алтангадас зорилго хамгийн үр дүнтэй санагдсан. Мөн дараа дараагийн хичээлүүд бас маш үр дүнтэй, уялдаа холбоотой байв. Байгууллагынхаа баримт бичгүүдийг цэгцэлж, янзлах, стратегийн баримт бичгүүдээ сайжруулан боловсруулж авсан. 2025 онд манай байгууллагын стратеги яг дуусаж байсан үед энэ төсөлд хамрагдсан нь маш их хэрэгтэй байлаа. Яриаг үзэх: https://tinyurl.com/54fhux3y



Иргэний засаглал ТББ-ын Тэргүүн Б.Уганхүү: Өөрчлөлтийн дуу хоолой төсөлд манай байгууллага хамрагдаад хоёр жил болж байна. Мөн байгууллагын стратегиа “Алтангадас” аргачлалаар боловсруулаад цаашид хүрэх зорилго, зорилтуудаа боловсруулсан. Манай байгууллагын хувьд иргэний нийгмийн байгууллагын 9 зарчимд нэгдээд энэ зарчмуудаа баримтлаад ажиллаж байна. Ялангуяа энэхүү 9 зарчмын нэг болох “хараат бус” байх зарчмыг орон нутагтаа үйл ажиллагаагаа явуулахдаа баримтлан ажиллаж байна. Яриаг үзэх: https://tinyurl.com/zxmzm8pe



Өгөөмөр мэдээллийн товчооны захирал П.Энхмаа: Өөрчлөлтийн дуу холой төслийг хэрэгжүүлж эхлэх үеэс манай байгууллага оролцож эхэлсэн. Энэ төслийн хүрээнд олж авсан хамгийн том ололт нь “Менторшип” хөтөлбөрт хамрагдаж, өөрсдөдөө чин үнэнчээр аудит хийж, болж байгаа болохгүй байгаа зүйлээ мэдэж авсан. Үүний дагуу дагаж мөрдөх журмуудтай болсон. Үнэхээр хэрэгтэй хөтөлбөрт хамрагджээ гэж бодож байна. Яриаг үзэх: https://shorturl.at/1X0RR



МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээний хөтөлбөрийн ажилтан Г.Нямсүрэн: Манай байгууллагын хувь “Өөрчлөлтийн дуу хоолой” төслийн хүрээнд “Алтангадас” зорилгоо тодорхойлох сургалтад багаараа хамрагдсан. Мөн маркетингийн сургалтад хамрагдаж, түүний хүрээнд рийлс гаргаж түгээсэн нь хүмүүст хүрч байгаа шүү. Өнөөдрийн хувьд би анх удаа туршлагаа хуваалцаж илтгэл танилцуулж байгаа нь маш гоё туршлага болж байна. Яриаг үзэх: https://shorturl.at/PfWXX



Эмэгтэйчүүд, залуучуудын Оюуны сан Үндэсний сүлжээний (ЭЗОС) ТББ-ын Тэргүүн Док.Ц.Бүжидмаа: Эмэгтэйчүүд, залуучуудын оюуны сан үндэсний сүлжээ ТББ: Хөгжлийн төлөөх түншлэл чуулганд Иргэний нийгмийн байгууллагуудын баримтлах зарчмын тухай яригдлаа. Энэхүү иргэний нийгмийн байгууллагын хариуцлагын 9 зарчмыг хэрэгжүүлсэн байгууллагуудын туршлагыг хуваалцах нь үр өгөөжтэй байна. Яриаг үзэх: https://shorturl.at/4YQUi

Чуулганы төгсгөлд 10 иргэний нийгмийн байгууллага сайн дурааараа “Хөгжлийн төлөөх хариуцлага: Иргэний нийгмийн санаачилга”-ын зарчмуудад нэгдэж, дэмжихээ илэрхийлэв. 2025 оны чуулганаар 18 байгууллага мөн нэгдэж, дэмжихээ илэрхийлж байв.

“Өөрчлөлтийн дуу хоолой” төсөл



Хил хязгааргүй алхам төв ТББ
Газрын эзэн баян зүрх нөхөрлөл
Даацтай хөгжлийн ирээдүй
Монголын байгаль хамгаалагчдын холбоо
Иргэний боловсролын төв
Сонгогчдын боловсрол төв
Иргэний засаглал ТББ
Таны Эрх-Эгэл нандин
Ил тод байдал сан
Өгөөмөр мэдээллийн товчоо
Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбоо
МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээ
Либерал эмэгтэйчүүдийн Оюуны сан
Хөгжлийн туслалцаа төв
Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг
ЭЗОС үндэсний сүлжээ (Эмэгтэйчүүд, залуучуудын оюуны сан)
Гэрэлт цох байшин ТББ
Сонгогч төлөөлөгчийн хамтын оролцоо ТББ
Тодоос Тод Од ТББ



Захиргааны шинэ санаачилга
IWPG Дэлхийн эмэгтэйчүүд Энхтайваны Соёл Нийгэмлэг (Солонгосын IWPG байгууллагын Монгол дахь салбар)
Youth LEAD Mongolia ТББ
Баян-Өлгий “Танд тус дэм болъё” ТББ
Бүсгүйчүүд 21-р зуун ТББ
Гэрэлт Ирээдүй Номын Өргөө Төв ТББ
Монголын Сошиал Энтерпрайзуудын холбоо ТББ
Сувд хүмүүнлэг сан ТББ
Сүүн Эрчис ТББ
Улаанбаатар Ротаракт клуб ТББ, МЗХ-ны дэргэдэх Эмэгтэйчүүдийн зөвлөл
Эко ногоолин иргэдийн хөгжлийн холбоо НҮТББ
Эмэгтэйчүүд Амьдрал төв ТББ

Хараат бус судлаач Ц.Батсугарын чуулганы талаар бичсэн хөндлөнгийн ажиглалттай эндээс бүрэн эхээр нь танилцана уу. Түүний ажиглалтын дүгнэлт хэсгээс: … Иргэний нийгмийн чуулган иргэний орон зайг хамгаалах, иргэний нийгмийн хариуцлагыг бэхжүүлэх, салбарын хөгжлийн сорилтуудыг хэлэлцэх нэн чухал төдийгүй нэн ховор талбар байв. Иргэний суурь эрх чөлөө хязгаарлагдаж, иргэний орон зай хумигдаж, иргэний нийгмийн салбарт сорилтууд нэмэгдэж буй энэ цаг үед чуулганы ач холбогдол улам бүр өндөр байлаа. Оролцсон төрийн бус байгууллагууд чуулж өөрсдийн сөрөн тэсвэрлэх чадварын, хариуцлагатай хөгжлийн туршлагаа хуваалцсан нь иргэний нийгмийн хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлж байна. Иргэний нийгмийн байгууллагууд нээлттэй, ил тод, хариуцлагатай, тэгш хүртээмжтэй, оролцоотой, тогтвортой иргэний орон зайг төлөвшүүлэхийг зорьж байна. Хөгжлийн төлөөх эгэх хариуцлага: иргэний нийгмийн санаачилгын зарчимд олон байгууллагууд нэгдэн орж буй нь үүний тод илэрхийлэл юм. Чуулганы шууд үр дүнд “Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлого”-ын төслийг хэлэлцэж, улмаар ерөнхийлөгчид өргөн барьсан нь ээлтэй бодлого, эрх зүйн орчныг цогцлоох чиглэлд хийж буй дорвитой алхам юм. Иргэний нийгмийн чуулганыг цаашид тогтмолжуулж, иргэний орон зайн тулгамдсан асуудал, салбарын хөгжлийн загварыг хэлэлцэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх талбар болгон өргөжүүлэх, оролцоо, хамрах хүрээг нэмэгдүүлэх нь иргэний нийгмийн хөгжил, сөрөн тэсвэрлэх чадавхийг бэхжүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэнэ. Цаашид дараагийн чуулганаар төр-иргэний нийгмийн түншлэлийн бодит механизм, иргэний орон зайн эрх зүйн шинэчлэл, татварын таатай орчин, орон нутгийн ИНБуудын чадавх, дижитал орчин дахь иргэний оролцоо, салбарын өөрийн удирдлагын механизмын хэрэгжилт зэрэг сэдвийг тусгайлан хэлэлцэх, шийдэл дэвшүүлэх, олон талт зөвшилцлийг бүрдүүлэх нь чухал. Мөн энэ удаагийн чуулганы мөрөөр ИНБ-уудын



хариуцлагатай засаглал, чадавх бэхжүүлэх ажлыг өргөжүүлэн үргэжлүүлэх шаардлагатай. Чуулганы үеэр ТББ-ууд хариуцлагатай, тогтвортой дотоод засаглалыг бэхжүүлэх сонирхол, хэрэгцээ байгаа нь тод ажиглагдсан. Түүнчлэн, салбарын өөрийн удирдлагын талаар ярих цаг болсон нь хурлын уур амьсгалаас мэдрэгдэж байлаа. Иймд салбарын өөрийн удирдлагын тогтолцоо, түүний зарчим, үнэт зүйл, хэрэгжүүлэх арга замын талаар дорвитой судалгаа, хэлэлцүүлгийг үргэлжлүүлбэл зохистой. Мөн иргэний орон зайн эрх зүйн ээлтэй орчныг бүрдүүлэх чиглэлд олон нийт, бодлого гаргагчдад чиглэсэн нөлөөллийн ажлыг ИНБ-ууд хамтран хэрэгжүүлэх нь чухал. Чуулганаар хөндөгдсөн эдгээр олон чухал сэдвийг ажил хэрэг болгохын тулд ИНБ-ууд зохион байгуулалтад орж тууштай ажиллах нь чухал бөгөөд үүнд хөгжлийн түншүүд болон бусад оролцогч талуудыг дэмжлэг зайлшгүй хэрэгцээтэй билээ.

ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭГЭХ ХАРИУЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ ГАРЫН АВЛАГА (TOOLKIT) БОЛОВСРУУЛЛАА

“Хөгжлийн төлөөх эгэх хариуцлага: Иргэний нийгмийн санаачилга” зарчмуудыг хэрэгжүүлэх гарын авлага, хэрэглэгдэхүүн (toolkit)-ийг боловсруулаа.

Энэхүү гарын авлага нь иргэний нийгмийн байгууллагуудын дотоод засаглал, ил тод байдал, эгэх хариуцлага, үйл ажиллагааны чанар, хөгжлийн үр нөлөөг сайжруулах, байгууллагын түвшинд эгэх хариуцлагын зарчмуудыг бодитоор хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилготой юм.

Гарын авлагыг боловсруулах ажлын хүрээнд төсөлд хамрагдаж буй 13 иргэний нийгмийн байгууллагаас санал, хэрэгцээ тодорхойлох судалгаа авч, үр дүнд нь тулгуурлан агуулгыг боловсруулсан байна. Мөн иргэний нийгмийн байгууллагын чадавх бэхжүүлэх чиглэлээр ажилладаг мэргэжлийн байгууллагуудтай зөвлөлдөж, олон улсын сайн туршлага, стандартуудыг судаллаа.

Тухайлбал, иргэний нийгмийн байгууллагын хөгжлийн үр нөлөөг нэмэгдүүлэх Истанбулын зарчмууд, Ac-countable Now стандарт, хүний эрхэд суурилсан хандлага, олон нийтийн оролцооны олон улсын аргачлал болон НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгууд зэрэг олон улсын баримт бичиг, сайн туршлагад үндэслэн хэрэглэгдэхүүний агуулгыг боловсруулсан юм.

Гарын авлагад эгэх хариуцлагын есөн зарчмыг байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрт хэрэгжүүлэх аргачлал, зөвлөмжийг тусгаснаас гадна хэрэгжилтийг үнэлэх, дүгнэх, сайжруулахад ашиглах практик хэрэгслүүдийг багтаажээ. Тухайлбал, зарчим тус бүрийн тодорхойлолт, ач холбогдол, хэрэгжүүлэх зөвлөмж, байгууллагын өөрийн үнэлгээний хэрэгсэл, шалгах хуудас, сайжруулах үйл ажиллагааны төлөвлөлтийг тусгасан байна.

Мөн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаанд эгэх хариуцлагын зарчмууд хэрхэн хэрэгжиж байгааг үнэлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор цахим үнэлгээний маягт, QR код болон гарын авлагыг ашиглах аргачлалын танилцуулгыг боловсруулжээ.

Энэхүү хэрэглэгдэхүүн нь иргэний нийгмийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааг үнэлэх, сайжруулах шаардлагатай чиглэлээ тодорхойлох, байгууллагын хөгжлийн төлөвлөлтдөө эгэх хариуцлагын зарчмуудыг тусгахад ашиглах практик ач холбогдолтой юм.

ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

“Өөрчлөлтийн дуу хоолой” төслийн “Иргэний нийгмийн байгууллагуудын консалтинг, менторшип хөтөлбөрийг” Сэтгүүл зүйн Инновац, хөгжлийн үүр төв 2024 оны 12-р сараас 2026 оны 9-р сар хүртэл хэрэгжүүлж байна. Төслийн эхэн үед шалгарч үйл ажиллагаанд хамрагдаж байсан 15 байгууллагаас 7 байгууллагыг өөрсдийн хүсэлтээр урт хугацааны хөтөлбөрт хамруулж эхэлсэн.

Байгууллагын засаглал, ил тод байдал, санхүүгийн тогтвортой байдал болон стратегийн хөгжлийг дэмжих цогц үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж буй. Онлоос практик хэрэглээ рүү шилжсэн сэдэвчилсэн сургалт, менторшип болон харилцан суралцах хөтөлбөрүүдийг түлхүү хэрэгжүүлж байна. Тухайлбал;

Чадавхжуулах багц сургалтууд: ИНБ-уудын урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилгоор Удирдах зөвлөлийн үүрэг хариуцлага, санхүүгийн хяналт, ашиг сонирхлын зөрчлийн менежмент, гомдол шийдвэрлэх журам зэрэг засаглалын сургалтуудыг зохион байгууллаа. Мөн байгууллагын танигдах байдлыг өсгөх брэндинг, харилцаа холбооны сургалтаас гадна санхүүгийн эх үүсвэрийг төрөлжүүлэх, төслийн санал боловсруулах бизнес хөгжлийн практик хичээлүүдийг орсон.

Уулзалтууд: Чадавхжуулах багц сургалтуудын практик ач холбогдлыг нэмэгдүүлэх ганцаарчилсан болон бүлгийн уулзалтуудыг тус тус зохион байгуулж байна.

“Хөгжлийн төлөөх эгэх хариуцлага: Иргэний нийгмийн санаачилга” иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаандаа баримтлах эгэх хариуцлагын зарчмуудаас байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд хариуцлагатай, ил тод байдлын зарчмуудыг уялдуулах боломжуудыг байнга эрэлхийлсэн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. .

- 2024 оны 12-р сарын 17-18-ны өдрүүдэд ИНБ-уудад зориулсан “Сошиал медиагийн хяналт” ИНБ-д зориулсан онлайн сургалт: Сургалтад иргэний нийгмийн салбарт ажилладаг 50 орчим мэргэжилтнүүд хамрагдсан. Энэхүү сургалтын хөтөлбөр нь сошиал медиагийн хяналт-шинжилгээний үндсэн ойлголт, гол хэмжигдэхүүнүүд болон өгөгдөл дүрслэх арга техникийг цогцоор нь эзэмшүүлэхэд чиглэсэн. Оролцогчид том хэлний загвар (LLM) ашиглан сэтгэл зүйн болон хортой контентын шинжилгээ хийх, сэдэв кластерчлах зэрэг практик ур чадварыг багийн дасгалаар дамжуулан суралцах, мөн “Arbiter” болон “Telegram” шинжилгээний тусгай хэрэгслүүдтэй танилцаж, иргэний нийгмийн байгууллагуудын бодит кейс судалгааг шинжлэн судлахыг зорьсон.
- 2024 оны 12-р сарын 24-нд хөтөлбөрийн нээлтийн уулзалт боллоо.
- 2025 оны 2-р сарын 19-нд “Хөгжлийн төлөөх эгэх хариуцлага: Иргэний нийгмийн санаачилга” иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаандаа баримтлах эгэх хариуцлагын зарчмууд - хэрэгжилтийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох уулзалт зохион байгуулсан.
- 2025 оны 4-р сарын 23-25-нд байгууллагын урт хугацааны стратегийг боловсруулах “Алтан гадас” аргачлалын сургалт боллоо. Оролцогч байгууллагууд сургалтын дараа байгууллага тус бүр ажлын дэвтэрийнхээ дагуу байгууллагынхаа урт хугацааны стратегийг боловсруулсан.
- 2025 оны 9-р сарын 17-18-нд “Иргэний нийгмийн байгууллагын засаглал, ил тод байдал” сургалт;
- 2025 оны 10-р сарын 24-25-нд Иргэний нийгмийн байгууллага олон нийттэй хэрхэн амжилттай харилцах вэ сургалт;
- 2026 оны 1-р сарын 31-нд Бизнесийн хөгжил буюу Иргэний нийгмийн байгууллагын төсөв бүрдүүлэлт, санхүүжилт сургалт;
- 2026 оны 5-р сарын 1-нд бүлгийн уулзалт;
- 2026 оны 5-р сараас хойш байгууллагуудтай ганцаарчилсан уулзалтуудыг тус тус хийж байна.









МУБИС-ИЙН СЭТГҮҮЛЗҮЙН БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ СУУРЬ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРТ ОРУУЛЛАА

МУБИС-ийн “VIBE MNUE” баримт нягтлан шалгах клуб нь оюутнуудын оролцоотой сургалт, олон нийтийн ажиллагаа, дижитал контент бүтээх болон VIBE.MN платформыг ажиллуулах замаар залуусын медиа боловсрол, баримт нягтлах ур чадварыг дээшлүүлэх зорилготой. Төслийн хүрээнд вэбсайт, товхимол, нээлттэй хаалганы өдөрлөг, олон нийтийн арга хэмжээнүүд, подкаст, влог, редакцын аялал, хөдөө орон нутгийн сурвалжилга болон жилийн эцсийн дүгнэлтийн арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөсөн. Мөн давтан сургалт, хэлэлцүүлгүүдээр дамжуулан 1000 гаруй сурагч, оюутанд хүрэх зорилт тавин ажиллаж байна. Түүнчлэн “Хэвлэл мэдээллийн суурь боловсрол” хичээлийг МУБИС-ийн Сэтгүүлзүйн бакалаврын хөтөлбөрийн ерөнхий суурь хичээлийн хөтөлбөрт оруулаа.

“VIBE MNUE” клубын контент мэдээллийг дараах сошиал медиа сувгуудаар хүлээн аваарай

- “VIBE MNUE” Fact-Checking Students (Facebook хуудас)
- Vibefactcheckingclub (Instagram)









Отгонтэнгэр их сургуулийн “CheckPlus” баримт нягтлан шалгах клуб сургалтын дэд бүтэц, нөлөөллийн ажил, сургалтын хөтөлбөр болон цахим сувгуудаа шинэчлэх зэрэг олон ажлыг амжилттай хэрэгжүүллээ. Багш, оюутнуудын оролцоотойгоор орчин үеийн подкаст студийг шинээр тохижуулан угсарч бэлэн болгосон бөгөөд эхний дугаарууддаа салбарын эрдэмтэн, хэвлэл мэдээллийн удирдлагуудыг урьж, сэтгүүлчийн хариуцлага, хэвлэлийн эрх чөлөөний сэдвээр сонирхолтой хэлэлцүүлэг өрнүүлсэн нь олон нийтэд амжилттай хүрсэн. Үүний зэрэгцээ “Баримт нягтлах арга зүй” хичээлийн шинэ хөтөлбөрийг боловсруулан баталж, клубийн оюутнуудыг чадавхжуулах сургалтуудад тогтмол хамруулсан. Мөн их сургуулийн оюутнууд болон ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдыг холбосон “Би ертөнц” нийтлэл, нэвтрүүлгийн уралдааныг Zarig.mn зэрэг сувгуудаар олон нийтэд зарлан амжилттай зохион байгууллаа. Уралдаанд ЕБС-ийн сурагчдаас 80 гаруй эссэ ирснээс гадна клубийн шилдэг оюутнуудын бүтээсэн улс төрийн оролцоо, хуурамч мэдээллийг таних сэдэвт контентууд шалгарсан байна. Клубийн лого, дүрмийг шинэчилж, Facebook болон YouTube сувгаар дамжуулан 25 богино хэмжээний видео бүхий 36 контентыг цахим орчинд нийтэлсэн нь залуусын дунд сэтгүүл зүй, үнэнийг эрэлхийлэх, медиа хариуцлагын талаарх сонирхлыг нэмэгдүүлсэн өндөр ач холбогдолтой байв.

“CheckPlus” клубын контент мэдээллийг дараах сошиал медиа сувгуудаар хүлээн аваарай.

- CheckPlus Student Club (Facebook хуудас)
- CheckPlus @CheckPlusStudentClub (YouTube)









МУИС-ийн “Сэтгүүлч” (NUM Journalists) баримт нягтлан шалгах клуб медиа боловсролыг дээшлүүлэх, баримт нягтлах дадлыг хэвшүүлэх чиглэлээр олон талт үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд контент бүтээх тоног төхөөрөмж худалдан авч, 25 гишүүндээ видео эвлүүлэг, зураг авалтын практик сургалт орсон. Тус клуб залуусын сонирхолд нийцсэн “Сэтгүүл зүйн ABC” тайлбар видео, хуурамч мэдээллийг нягталсан “Баримтаар нотлогдсон” цуврал, болон оюутны эрхийг хошин хэлбэрээр хөндсөн “МУИС Мааз” зэрэг нийт 10 цуврал контент бэлтгэн цахим орчинд 38,700 гаруй хандалт авч, сургууль доторх мэдээллийн гол суваг болжээ.

Цахим нөлөөллөөс гадна оюутнуудын шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх, мэргэжлийн дадлага олгох зорилгоор хоёр томоохон арга хэмжээг зохион байгуулав. Дөрөвдүгээр сарын 11-ний өдөр “BEST” болон “SNITCH” мэтгэлцээний клубүүдтэй хамтран медиа боловсролын сэдвээр 46 оролцогчийг хамарсан 10 сэдэвт мэтгэлцээний тэмцээн зохион байгуулжээ. Түүнчлэн “News Cafe”-д зохион байгуулагдсан “Сэтгүүл зүйн тухай ярилцъя” уулзалтаар клубийн 18 оюутан мэргэжлийн сэтгүүлчидтэй биечлэн уулзаж, салбарын үнэ цэн, практик туршлагаас чөлөөтэй хуваалцсан үр дүнтэй харилцан яриаг өрнүүллээ.

“NUM” клубын контент мэдээллийг дараах сошиал медиа сувгуудаар хүлээн аваарай.

- NUM Journalists (Facebook хуудас)
- num_journalists_club (Instagram)
- https://num-journalist.com/ (Website)







СУИС, КТМУС-ийн “Check-Lab” баримт нягтлан шалгах клуб 2026 оны 3 дугаар сарын 25-ны өдөр клубийн албан ёсны нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, 50 орчим оюутан, багш, төслийн төлөөлөгчдөд клубийн зорилго, цаашдын төлөвлөгөө болон баримт нягтлах үндсэн ойлголтуудыг танилцууллаа. Мөн клубийн үйл ажиллагааны дүрмийн төслийг боловсруулж, логоны уралдаан зарласнаас гадна мэдээллийн самбарын дизайныг гаргаж, тоног төхөөрөмж хадгалах шүүгээ худалдан авах зэргээр ажиллах орчин, дэд бүтцээ амжилттай бүрдүүллээ. Үүний зэрэгцээ залуусын бүтээлч сэтгэлгээ, баримт нягтлах чадварыг хөгжүүлэх менторшип болон практик сургалтуудыг шат дараатай зохион байгуулав. Энэхүү ажлын үр дүнд клубийн гишүүн О.Дэлгэрхишигийн бүтээсэн “Хуурамч мэдээлэл олон нийтийн сэтгэл зүйд хэрхэн нөлөөлдөг вэ?” мультимедиа бүтээл оюутны уралдаанд тэргүүлж, нэг жилийн сургалтын төлбөрийн тэтгэлэг хүртсэн байна. Клуб Facebook хуудас болон дотоод харилцааны сувгуудаа нээн, төслийн санхүүжилтээр авсан техник хэрэгслийг ашиглан 14 нэр төрлийн онлайн контент нийтэлсэн бөгөөд эдгээр нь цахим орчинд 4,900 гаруй үзэлт, 1,200 гаруй хандалт цуглуулж, залуусын дунд баримттай мэдээллийг түгээх чухал суваг болон хөгжиж байна.

“CheckLab ” клубын контент мэдээллийг дараах сошиал медиа сувгуудаар хүлээн аваарай.

- MNUAC SBMA Student Fact





Checking Club (Facebook хуудас)

КЛУБҮҮДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮРГЭЛЖЛЭВ

“Өөрчлөлтийн дуу хоолой” төслийн хүрээнд Сэтгүүл зүйн инновац, хөгжлийн үүр төвөөс Отгонтэнгэр их сургууль, МУБИС дээр тус тус оюутны баримт нягтлан шалгах клубүүдийг үүсгэн байгуулах ажлыг эхлүүлж, клубүүдийг чадавхжуулах сургалт, уулзалтуудыг зохион байгуулж байна.

****

2025 оны 12-р сарын 4-нд Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн (МУБИС) оюутнуудад “Тайлбарлах сэтгүүл зүй” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав. Энэхүү уулзалтын гол зорилго нь хурдацтай тархаж буй хуваагдмал, төөрөгдүүлсэн мэдээллийн орчинд үйл явдлын шалтгаан, нөхцөл, нийгмийн үр нөлөөг тайлбарлан таниулдаг тайлбарлах сэтгүүл зүйн ач холбогдлыг оюутнуудад танилцуулахад чиглэсэн байна. Уулзалтаар мэргэжлийн сэтгүүлч оюутнуудад улс төр, эдийн засаг, нийгмийн нарийн төвөгтэй асуудлуудыг үнэн зөв, гүн гүнзгий бөгөөд олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр хэрхэн хүргэж, түүх болгон хүүрнэх арга техникийг талаар ярилцсан. Нээлттэй хэлэлцүүлгийн үеэр оюутнууд сэтгүүл зүйн ёс зүй, мэдээллийн эх сурвалжийн найдвартай байдал, хуурамч мэдээлэлтэй тэмцэх сорилтуудын талаар идэвхтэй асуулт асууж, харилцан санал солилцсон байна.



****

2025 оны 12-р сарын 8–нд Отгонтэнгэр их сургуулийн оюутнуудад ахисан шатны онлайн сургалт, менторшип уулзалтыг амжилттай зохион байгууллаа. Энэхүү үйл ажиллагаа нь оюутнуудын баримт нягтлах арга зүй, дижитал орчин дахь мэдээллийг шалгах техник болон хариуцлагатай сэтгүүл зүйн талаарх ойлголтыг бэхжүүлэх зорилготой байв. Сургагч багш оролцогчдод мэдээллийн эх сурвалжийг үнэлэх, цахим платформ дээрх хуурамч мэдээлэлтэй тэмцэх мэргэжлийн ажлын урсгал, зураг болон онлайн мэдээллийг баталгаажуулах дижитал хэрэгслүүдийг практик жишээн дээр тулгуурлан танилцуулсан байна.

****

2026 оны 2-р сарын 26-нд Отгонтэнгэр их сургууль дээр тайлбарлах сэтгүүл зүйн сургалтыг зохион байгууллаа. Энэхүү сургалт нь оюутнуудын тайлбарлах сэтгүүл зүйн талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх, улс төр, эдийн засаг, нийгмийн нарийн төвөгтэй асуудлуудыг олон нийтэд илүү тодорхой, бүтэцтэй, ойлгомжтой хэлбэрээр хүргэх ур чадварыг хөгжүүлэх зорилготой байв. Сургалтаар өгүүлэмж үүсгэх аргууд, уншигчдад чиглэсэн сурвалжилга бэлтгэх арга техник, орчин үеийн медиа орон зайд хуурамч мэдээлэлтэй тэмцэхэд тайлбарлах сэтгүүл зүйн гүйцэтгэх үүргийг онол, практик хослуулан танилцуулсан байна.



2026 оны 3-р сарын 5-нд МУИС, МУБИС, Кино телевиз медиа урлагийн сургууль, Хүмүүнлэгийн ухааны их сургууль, Отгон тэнгэр их сургуулийн “Оюутны баримт нягтлах клуб”-ын нийт 55 оюутан оролцсон хагас өдрийн уулзалт, нетворкинг арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Энэхүү үйл ажиллагаа нь оюутнуудын харилцаа холбоо, хамтын ажиллагаа, харилцан суралцах үйл явцыг бэхжүүлэх, мөн тэдний мэргэжлийн хүсэл эрмэлзлийг дэмжин, медиа бүтээл туурвих шинэлэг аргуудыг эрэлхийлэх интерактив орон зайг бүрдүүлэх зорилготой байв. Арга хэмжээний эхэнд оюутнууд төгсөөд сэтгүүл зүйн салбарт ажиллахад тулгардаг ажлын байрны тогтвортой байдал, ёс зүйн сорилт, хуурамч мэдээллийн дарамт зэрэг өөрсдийн айдас, тулгамдсан асуудлаа нэрээ нууцлан хуваалцаж, харилцан бие биенээ дэмжих нээлттэй уур амьсгалыг бүрдүүлсэн бөгөөд сэтгүүлчийн хариуцлагын тухай богино хэмжээний баримтат кино үзэж хэлэлцүүлэг өрнүүлсэн.



****

2026 оны 3-р сарын 24-нд Отгонтэнгэр их сургуулийн “Би ертөнц” тэмцээнд оролцож буй оюутнуудад зориулан баримт нягтлах ахисан түвшний сургалтыг зохион байгууллаа. Тус сургалт нь оюутнуудын практик чадварыг бэхжүүлэх, дижитал орчин дахь хуурамч мэдээллийг илрүүлэх, бичвэр болон зураг/дүрс бичлэгийг шалгах, эх сурвалжийн найдвартай байдлыг үнэлэхэд чиглэсэн байна. Мөн тэмцээний даалгавруудаа баримт баталгааг зөв ашиглах, чанартай бүтээл туурвихад нь туслах зорилгоор мэргэжлийн чиглүүлэг (mentor-ship) болон зөвлөмжүүдийг өгч, үйл ажиллагааг оюутны Баримт нягтлах клубийн ажилтай уялдуулан явуулжээ.

****



2026 оны 3-р сарын 27-нд Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн (МУБИС) оюутнуудад практикт суурилсан “Баримтад тулгуурласан эрэн сурвалжилга” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Энэхүү үйл ажиллагаа нь оюутнуудад эрэн сурвалжлах сэтгүүл зүйн практик арга барилыг эзэмшүүлэх, баримтаар нотлогдсон мэдээлэл болон баримт нягтлах арга зүйг хэрхэн олон нийтэд хүртээмжтэй, нөлөөлөл өндөртэй эрэн сурвалжлах бүтээл болгохыг талаар мэдээлэл өгөх зорилготой байв. Сургалтаар баримт нотолгоонд суурилсан сэтгүүл зүй, хүүрнэл зохиомжийн хөгжүүлэлт, мэргэжлийн ёс зүй зэрэг сэдвүүдийг хөндөж, салбарын туршлагатай мэргэжилтнээс шууд суралцах боломжийг оюутнуудад олгосон байна. Сургалтын явцад оролцогчид баримт нягтлах үйл явц нь эрэн сурвалжлах бүтээлийн үнэ цэн, нийгмийн нөлөөллийг хэрхэн нэмэгдүүлдэг талаар судалж, мэдээллийг цэгцлэх, сэдвийн өнцөг гаргах, эх сурвалжийг магадлах болон баримтын нарийвчлалыг хадгалах практик аргуудыг суралцжээ.



****

“ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН АЛЬТЕРНАТИВ ХУУЛИЙН ТӨСӨЛ — ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙР СУУРИА НЭГТГЭХ НЬ” ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ БОЛЛОО

2026 оны 2 дугаар сарын 27–28-ны өдрүүдэд Хэвлэл Мэдээллийн Зөвлөл, Монголын Залуучуудын Эвсэлтэй хамтран 1997 оны Төрийн бус байгууллагын тухай хуулийн шинэчлэл, хуулийн хэрэгжилтийн үнэлгээ, цаашдын үйл ажиллагааны стратеги боловсруулах, иргэний нийгмийн байр суурыа нэгтгэх зорилготой зөвлөлдөх уулзалт зохион байгууллаа. Хоёр өдөр үргэлжилсэн арга хэмжээг МОНФЕМНЕТ үндэсний сүлжээний ерөнхий зохицуулагч Д.Энхжаргал ерөнхий чиглүүлэгчээр удирдсан бөгөөд иргэний нийгмийн консорциумын гишүүд болон бусад төрийн бус байгууллагын төлөөлөл зэрэг нийт 20 орчим оролцогчид оролцов.



Зөвлөлдөх уулзалтын эхний өдөр төрийн бус байгууллагын тухай хуулийн альтернатив байр суурь, анхаарах асуудлууд, хууль эрх зүйн орчны өнөөгийн байдал, хуулийн төсөлтэй нийцлийн үнэлгээ зэрэг сэдвүүдээр илтгэл тавьж, санал солилцлоо. Т.Энхжаргал (Монголын Залуучуудын Эвслийн зөвлөх, хуульч) альтернатив хуулийн төслийн талаар илтгэл танилцуулж, оролцогчдын хэлэлцүүлгээр цаашдын алхмуудыг тодорхойлов.

Хоёр дахь өдөр цаашдын үйл ажиллагааны зураглал гаргах, нэгдсэн байр суурь болгон нэгтгэх, бодлого боловсруулагчдад чиглэсэн зөвлөмж боловсруулах болон иргэний нийгмийн байгууллагын өөрийн удирдлагын механизмын санаачилгыг хэлэлцэв. Уулзалтаас гарсан санал, зөвлөмжүүдийг олон нийтэд хүргэх, төрийн болон бодлого тогтоогч талуудтай хамтран цаашдын төлөвлөгөөнд тусгах зорилготойг зохион байгуулагчид онцлов. Мөн цаашид тус зураглал төлөвлөгөөг Эмнести Интернэшнл болон Глоб Интернэшнл Төв төрийн бус байгууллага дэмжин оролцохоор тогтлоо.





ТББ-ын тухай хуулийн шинэчлэл болон иргэний нийгмийн өөрийн зохицуулалтын механизм холбоотой дагалдах ажлууд 3, 4 дүгээр сард эрчимтэй үргэлжилж, олон талт зөвлөлдөх уулзалтаар хуулийн төслийн заалт бүрийг нарийвчлан хэлэлцлээ:

- 3 дугаар сарын 10: “Эмнести Интернэшнл Монгол” байгууллагаас 10 орчим ИНБ-ын төлөөллийг оролцуулсан уулзалт зохион байгуулж, хуулийн төсөл дэх ИНБ-ын тодорхойлолт, тэдгээрийн хараат бус байдал болон олон улсын эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний зарчмыг хэрхэн тусгах талаар санал солилцов.
- 3 дугаар сарын 17: “Глоб Интернэйшнл” төвд мөн 10 гаруй төлөөлөгч цугларч, ИНБ-уудын санхүүгийн хараат бус байдал, татварын зохицуулалт болон санхүүгийн тогтвортой байдлын механизмыг хуулийн төсөлд хэрхэн тусгах асуудлыг хөндлөө.
- 4 дүгээр сарын 16: Хэвлэл мэдээллийн зөвлөлд болсон ойролцоогоор 20 ИНБ-ын төлөөллийг хамарсан уулзалтаар хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим, дотоод дүрэм журам болон хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын туршлага, түүний ач холбогдлыг танилцуулж, ижил төстэй хариуцлагын тогтолцоог иргэний нийгмийн салбарт хэрхэн нутагшуулах талаар хэлэлцүүлэг өрнүүлэв.
- 5 дугаар сарын 28: Цогц хөгжлийн төвд болсон ИНБ-уудын ээлжит уулзалтаар иргэний нийгмийн салбарын засаглал, салбарын өөрийн удирдлагын тогтолцооны талаар нарийвчлан хэлэлцэж, хэрэгцээ шаардлага болон тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлов.

Төслийн үр дүнг урт хугацаанд хадгалах үүднээс хуулийн шинэчлэл болон өөрийн зохицуулалтын хүрээнд хуримтлуулсан мэдлэг, эрх зүйн баримт бичгийн төслүүдийг Иргэний нийгмийн консорциумд албан ёсоор шилжүүлэн өгөхөөр тохиролцлоо. Цаашид энэхүү шинэчлэлийн үйл ажиллагаа Консорциумын удирдлага дор үргэлжлэх бөгөөд Монголын залуучуудын эвсэл болон Хэвлэл мэдээллийн зөвлөл нь өөрсдийн мэргэжлийн чиглэлээр нөлөөллийн ажлуудыг үргэлжлүүлэн дэмжихээр боллоо. Үүний үр дүнд төслийн үр өгөөж институцийн түвшинд хадгалагдаж, салбарын байгууллагуудын манлайлал дор тасралтгүй үргэлжлэх суурь тавигдаж байна.

Судлаач Д.Тэгшбаярын “Төрийн аясаар: Иргэний нийгэм санхүүжилтийн төлөө алга таших ёстой юу?” (The state is calling the tune: ‘Should the Civil Society Applause for Funding?) нийтлэлийг эндээс уншиж танилцана уу.

“ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН АЛЬТЕРНАТИВ ХУУЛИЙН ТӨСӨЛ — ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙР СУУРИА НЭГТГЭХ НЬ” ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ БОЛЛОО

2023-2026 онд хэрэгжиж буй “Өөрчлөлтийн дуу хоолой: Иргэний нийгмийн байгууллагууд эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн ойлголтын төлөө хүчээ нэгтгэх нь” төслийн хүрээнд залуучууд болон эмзэг бүлгийн эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг Монголын иргэний нийгмийн байгууллагуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх төсөлд саналаа ирүүлэхийг 2026 оны 2-р сард зарлав. Уг төслүүдээр Улаанбаатар хотын гэр хорооллын бүсэд, мөн бусад холбогдох орчинтой холбоотой үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг дэмжих зорилготой. 11 байгууллага төслийн саналаа ирүүлсэн. Олон сонирхолтой төслийн саналуудаас “Сонгогч, төлөөлөгчийн хамтын оролцоо”, “Тодоос тод од”, “Гэрэлт цох байшин”, “Эмэгтэй удирдагч сан”-гийн дөрвөн төсөл шалгарлаа.

Сонгогч, төлөөлөгчийн хамтын оролцоо: Чингэлтэй дүүргийн нэгэн хороог сонгон, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралын чанарыг сайжруулах “Гэрээсээ гарцгаая” (Get Out of the House) хэмээх 3 сарын хугацаатай сонирхолтой туршилтын төслийг хэрэгжүүлнэ. Тус төсөл нь “iGishuun” платформыг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих хөдөлгөөнд тулгардаг дэд бүтцийн саад бэрхшээлийг олон нийтийн оролцоотойгоор илрүүлж, 300-аас доошгүй гео-шошго бүхий цахим зураглал үүсгэх, улмаар 800 орчим иргэнийг хамарсан судалгаа болон 10 гаруй цэгт нарийвчилсан аудит хийж Суурь тайлан бэлтгэх зорилготой юм.

Үүний зэрэгцээ орон нутгийн ЗДТГ-тай хамтран дэд бүтцийг сайжруулах 3-аас доошгүй шуурхай шийдлийг (quick-win) бодитоор хэрэгжүүлж, сэтгүүлчдийг тэргэнцэртэй алхуулах туршилтын өдөрлөг болон дата-медиа сургалтаар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай нарийн мэдрэмжтэй 3–5 контент хамтран бүтээхээр төлөвлөсөн. Түүнчлэн дүүргийн Засаг дарга болон УИХ-ын гишүүдийг тухайн маршрутаар биечлэн алхуулж, бодлогын 3-аас доошгүй амлалт авахын зэрэгцээ туршилтын хорооны 2–5 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байранд зуучлан, төслийн төгсгөлд энэхүү өгөгдөлд суурилсан загварыг бусад дүүргүүдэд хэрэгжүүлэх боломжтой “Түгээн дэлгэрүүлэх гарын авлага” (Scale-Up Tool-kit) бэлтгэж хүлээлгэн өгөхийг зорьж байна.

Төслийн нэр: “Гэрээсээ гарцгаая” (Get out of the house)
Дэмжлэгийн дүн: 7000 евро

Тодоос тод од: Төслийнхөө хүрээнд Улаанбаатар хотын гэр хорооллын 1-2 сургуулийг сонгон, хүүхдүүд өөрт тулгарсан сөрөг асуудлуудыг нэрээ нууцлан мэдээлэх боломжтой анхны энгийн загвар (MVP) цахим хэрэгслийг ашиглаж, анхны суурь өгөгдөл, хандлагуудыг цуглуулах юм. Түүнчлэн холбогдох төрийн болон хүүхэд хамгааллын байгууллагуудыг хамруулан өнөөгийн гомдол гаргах сувгуудын нөхцөл байдалд үнэлгээ хийж, гарсан үр дүнгүүдийг хоёр удаагийн дугуй ширээний уулзалтаар хэлэлцүүлэн зөвлөмж боловсруулахаар төлөвлөж байна. Цугларсан өгөгдлийг олон нийтэд ойлгомжтой байдлаар сонирхолтой контентуудыг хамтран бүтээж, хэвлэл мэдээллийн хариуцлагатай оролцоог дэмжихийг зорьж байна. Төслийн үр дүнд хүүхдийн аюулгүй байдлын өгөгдлийн тогтолцоог бүрдүүлэх Бодлогын зөвлөмжийг бэлтгэж, шийдвэр гаргагчид болон иргэний нийгмийн түншүүдэд хүргүүлэх юм.

Төслийн нэр: “Тод од”
Дэмжлэгийн дүн: 7000 евро

Гэрэлт цох байшин: Хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын сурч боловсрох эрхийг хамгаалах, их, дээд сургуулиудад тэгш хүртээмжтэй орчин бүрдүүлэх зорилготой “Хүртээмжтэй суралцах нь: Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан боломжит зохицуулалт” төслийг хэрэгжүүлнэ. Тус төслийн хүрээнд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 48 их, дээд сургуулийг хамруулан хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын тоог гаргах, тэднийг дэмжих бүтэн цагийн ажилтан томилсон эсэхийг тодорхойлох тоон суурь судалгааг хийж, цаашид мэргэжлийн зөвлөх үйлчилгээг нэвтрүүлэх ирээдүйн түнш сургуулиудыг сонгон шалгаруулах юм. Мөн олон нийт болон салбарын оролцогч талуудын ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэхийн тулд судалгааны үр дүнг танилцуулсан богино хэмжээний аудио-визуал контент бүтээхээс гадна хичээл, шалгалтын үеэр багш, оюутны хамтын ажиллагааны тусламжтайгаар бодит зохицуулалтыг хэрхэн хийж, ашиглаж буйг харуулсан жишээ контентыг бэлтгэж, өөрийн Tokhiruulga.mn цахим хуудас болон бусад онлайн сувгуудаар түгээн дэлгэрүүлэх цогц үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Төслийн нэр: “Хүртээмжтэй суралцах нь: Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан боломжит зохицуулалт” (Accessibly Learning: Reasonable Accommodation for Learners with Disabilities)
Дэмжлэгийн дүн: 4995 евро

Эмэгтэй удирдагч сан: Захын гэр хорооллын залуучууд, залуу эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэнд, боловсролын нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилготой “Залуусын дуу хоолойн дата шинжилгээ” (Data-Driven of the Young Voices) төслийг хэрэгжүүлнэ. Тус төслийн хүрээнд Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн хороог сонгон авч, нийгмийн эмзэг бүлгийн залуусыг хамруулан нийгмийн үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдал, бодит хэрэгцээг тодорхойлох асуумж судалгаа, фокус бүлгийн уулзалтуудыг зохион байгуулж, цогц мэдээллийн сан, асуудлын зураглалыг бий болгоно. Мөн хороо тус бүрд залуусын чадавхыг бэхжүүлэх сургалт явуулж, залуучуудаас бүрдсэн ажлын хэсгүүдийг байгуулахын зэрэгцээ сэтгүүлчдийн багтай хамтран залуусын бодит амьдралын кейсүүдийг хөндсөн подкаст, сошиал медиа кампанит ажил болон нээлттэй хэлэлцүүлгүүдийг өрнүүлэх ажээ. Төслийн үр дүнд цугларсан өгөгдөлд тулгуурласан бодлогын санал зөвлөмжийг боловсруулж, танилцуулан хууль эрх зүй, бодлогын түвшинд нөлөөлөх нөлөөллийн ажлыг гүйцэтгэхээр бэлтгэж байна.

Төслийн нэр: “Залуусын дуу хоолойн дата шинжилгээ”
Дэмжлэгийн дүн: 6781 евро

ДЭЛХИЙН ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН СЭТГҮҮЛ ЗҮЙН ОЮУТНУУДТАЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ӨРНҮҮЛЛЭЭ

Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг тохиолдуулан “Энх тайван ирээдүйг цогцлоох нь” уриан дор Хэвлэл мэдээллийн зөвлөл (ХМЗ) болон Сэтгүүл зүйн инновац, хөгжлийн үүр төвтэй хамтран “Өөрчлөлтийн дуу хоолой” төслийн тэтгэлэгт МУИС, МУБИС, Отгонтэнгэр, СУИС-ийн КТМУС-ийн баримт шалгагч оюутан клубуудтай “Сэтгүүл зүйн ёс зүй ба хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт” сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүллээ. Уулзалтаар МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн дэд профессор, ХМЗ-ийн Ёс зүйн хорооны гишүүн Д.Идэржаргал болон “Зууны мэдээ” сонины тоймч, ХМЗ-ийн Ёс зүйн хорооны гишүүн Б.Нямсүрэн нар Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)-аас жил бүр ардчилсан орнуудын хэвлэл мэдээллийн оролцоо, өөрийн зохицуулалтын хөгжлийг дэмжих зорилгоор зохион байгуулдаг “Role of Media in Democratic Countries” олон улсын Co-Creation хөтөлбөрт хамрагдсан туршлага, сэтгэгдлээсээ хуваалцаж “Ардчилсан тогтолцоон дахь хэвлэл мэдээллийн үүрэг” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.



ХМЗ-ийн Радио, телевиз, сайтын ёс зүйн хорооны орлогч дарга Ц.Чимэддондог “Сэтгүүлчийн ёс зүй, хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим” сэдвээр, ХМЗ-ийн Сонин, сэтгүүл, сайтын ёс зүйн хорооны дарга Х.Болормаа “Сэтгүүл зүйн бүтээлийн ёс зүйтэй холбоотой гомдлыг хэрхэн шийдвэрлэдэг вэ?” сэдвээр тус тус мэдээлэл хүргэж, хорооны үйл ажиллагааг танилцууллаа. Мөн Сэтгүүл зүйн инновац, хөгжлийн “Үүр” төвийн хөтөлбөрийн менежер Л.Анударь “Сэтгүүл зүйн ёс зүйн стандарт нутагшуулах нь: JTI гэж юу вэ?” сэдвээр илтгэл хэлэлцүүлж, хуурамч мэдээлэлтэй тэмцэх “Сэтгүүл зүйн итгэлцлийн санаачилга”-ыг танилцууллаа.

МУИС-ийн “NUM Journalist”, МУБИС-ийн “VIBE MNUE”, СУИС-ийн “CheckLab” болон Отгонтэнгэр их сургуулийн “CheckPlus” клубууд үйл ажиллагаагаа танилцуулж, харилцан туршлага хуваалцав. Хэлэлцүүлгийн төгсгөлд Хэвлэл мэдээллийн зөвлөлийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтыг бэхжүүлэх болон салбарын ёс зүйн стандартыг төлөвшүүлэхэд залуучуудын оролцоо чухал болохыг тэмдэглэж, тэдний идэвх санаачилгыг сайшааж буйгаа илэрхийллээ.

ЕВРОПЫН ӨДӨРЛӨГ 2026 БА “ӨӨРЧЛӨЛТИЙН ДУУ ХООЛОЙ” ТӨСӨЛ

Энэ жилийн тавдугаар сарын 23-ны өдөр Дархан хотын “Найрамдал” талбайд болсон “Европын өдөрлөг 2026” үйл ажиллагаанд “Өөрчлөлтийн дуу хоолой” төсөл оролцож олон нийтэд төслийн үйл ажиллагааны явцын мэдээллийг хүргэлээ. Жил бүр зохион байгуулагддаг уг үйл ажиллагаагаар Европын соёл, боловсрол, аялал жуулчлал, тэтгэлэг, танин мэдэхүйн сонирхолтой мэдээлэл, ЕХ-ны санхүүжилттэй төсөл хөтөлбөрүүд мэдээллээ хүргэдэг. Энэ жил 70 гаруй асарт байгууллагууд үйл ажиллагаа танилцуулж, 5000 гаруй иргэд олон нийт ирж танилцлаа.











ӨӨРЧЛӨЛТИЙН ДУУ ХООЛОЙ:
ХҮРСЭН ҮР ДҮНГҮҮД

VOICES OF CHANGE:
ACHIEVED RESULTS

Funded by the European Union · DW Akademie · Media Council of Mongolia · Voices for Change

Баримт шалгах сургалт
Fact-checking training

30 орчим иргэний нийгмийн байгууллагын 50 төлөөлөгч баримт нягтлах, мэдээлэлд мониторинг хийх арга зүйд суралцав.
Around 50 representatives from approximately 30 civil society organizations were trained in fact-checking and media monitoring methodologies.

Үйл ажиллагаа
Activities

Эрх зүйн орчны мониторингийн уулзалтууд
Legal environment monitoring meetings

Төр, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн гурван талт хамтарсан уулзалт хэлэлцүүлгийг 5 удаа зохион байгууллаа.
Five trilateral dialogue meetings among government, civil society, and media representatives were organized.

Engage & Learn залуучуудын сургалт
Engage & Learn youth training

“Engage & Learn” сургалтад оролцсон 30 залуус дижитал оролцоо, манлайлал, нөлөөллийн арга зүйд суралцав.
Thirty young participants attended the “Engage & Learn” training aimed at strengthening youth digital participation and leadership.

Хүрсэн үр дүн
Outcome

Иргэний нийгмийн байгууллагуудын эрх зүйн орчны судалгаа, бодлогын баримт бичиг
Research and policy papers on the CSO legal environment

Иргэний нийгмийн эрх зүйн орчныг дэмжих 2 тэтгэлэгт судалгаа хийж, нотолгоонд суурилсан санал, зөвлөмж гаргалаа.
Two grant-supported research studies were conducted, producing evidence-based recommendations on CSO legal reform and alignment with international standards.

Хакатон
Hackathon

“Hack the Future” хакатонд 100 гаруй залуус бүртгүүлж, 55 залуус 11 багт хуваагдан өрсөлдлөө.
More than 100 youth registered for the “Hack the Future” hackathon, with 55 participants competing in 11 teams.

MIL / Баримт нягтлах клуб байгуулах
Establishment of MIL / Fact-Checking clubs

МУБИС, Отгонтэнгэр их сургуульд Оюутан клубууд байгууллаа.
Student clubs were established at the Mongolian National University of Education and Otgontenger University.

Цахим мэдээлэл түгээх ёс зүйн удирдамж
Ethical guidelines for online information dissemination

Иргэний нийгмийн байгууллагууд “Цахим орчинд мэдээлэл түгээхэд баримтлах ёс зүйн удирдамж”-тай боллоо.
Civil society organizations adopted ethical guidelines for disseminating information in the digital environment.

Тэтгэлэгт хөтөлбөрүүд хэрэгжиж байна
Grant programs (FSTPs) implemented

Баримт шалгагч, мэдээллийн боловсролыг дэмжигч 4 оюутан клубт 45,000 еврогийн санхүүгийн тэтгэлэг олголоо.
€45,000 in financial support was awarded to 4 student clubs promoting fact-checking and media literacy.

ӨӨРЧЛӨЛТИЙН ДУУ ХООЛОЙ:
ХҮРСЭН ҮР ДҮНГҮҮД

VOICES OF CHANGE:
ACHIEVED RESULTS

Funded by the European Union · DW Akademie · Media Council of Mongolia · Voices for Change

Сургагч багшийн сургалт
Training of Trainers (ToT)

Сургагч багш бэлтгэх сургалтад 21 иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл хамрагдаж, насанд хүрэгчдийн сургалтыг үр дүнтэй явуулах арга техникт суралцав, үйл ажиллагаандаа ашиглаж эхлэв.
21 representatives of civil society organizations participated in the Training of Trainers program and gained practical skills and methodologies for effective adult training, which they have begun applying in their work.

Үйл ажиллагаа
Activities

Иргэний нийгмийн байгууллагууд эгэх хариуцлага, ил тод байдлын зарчмуудаа тодорхойллоо.
CSOs identified principles of accountability and transparency.

Хөгжлийн төлөөх эгэх хариуцлага: иргэний нийгмийн санаачилга” иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагаанд баримтлах эгэх хариуцлагын зарчимд 28 ТББ нэгдэж, 7 байгууллага нутагшуулах хөтөлбөрт хамрагдаж байна.
Under the initiative “Accountability for Development: A Civil Society Initiative”, 28 CSOs endorsed accountability principles for civil society organizations, and 7 organizations are participating in a localization program.

Иргэний нийгмийн байгууллагуудад засаглал, стратеги төлөвлөлтийн менторшип
CSO governance and strategic planning mentorship

Сайн засаглалд хөтлөх “Алтангадас” менторшип хөтөлбөрт хамрагдсан 7 ТББ стратеги төлөвлөлт, засаглал, ил тод байдал, байгууллагын хөгжлийн төлөвлөгөөгөө гаргалаа.
Seven CSOs participating in the “Altangadas” mentorship program for good governance developed strategic plans, governance frameworks, transparency mechanisms, and organizational development plans.

Хүрсэн үр дүн
Outcome

Иргэний нийгмийн байгууллагуудад хэвлэл мэдээлэлтэй харилцах сургалт
CSOs Media Training

“Хэвлэл мэдээлэлтэй харилцах нь” сургалтад 55 ТББ-ын төлөөлөл хамрагдаж, сэтгүүл зүйн 24 хамтын бүтээлийг нийтэллээ.
55 CSO representatives participated in the “How to Communicate with the Media” training, resulting in the publication of 24 collaborative journalistic pieces.

Иргэний нийгмийн байгууллага - сэтгүүлчдийн хамтарсан контент үйлдвэрлэл
Collaborative content production between CSOs and journalists

Үндэсний болон орон нутгийн хэвлэл мэдээллээр сэтгүүл зүйн 24+ хамтын бүтээлийг олон нийтэд хүргэлээ.
More than twenty-four collaborative journalistic works were disseminated through national and local media outlets.

Иргэний нийгмийн чуулган
Civil Society Summit

Иргэний нийгмийн өдөр (1-р сарын 31)-ийг тохиолдуулан 2025, 2026 онд “Иргэний нийгмийн чуулган” зохион байгуулж 200 төлөөлөл хамруулав.
In celebration of Civil Society Day (January 31), the “Civil Society Summit” was organized in 2025 and 2026, engaging 200 participants.

Иргэний нийгмийн байгууллагуудын техникийн чадавх бэхжүүлэх дэмжлэг
Technical capacity building support for CSOs

Иргэний нийгмийн байгууллагын дижитал чадавхыг дэмжих 24,000 еврогийн бичил тэтгэлэгт хөтөлбөрийг 5 ТББ хэрэгжүүлэв.
Five CSOs implemented a €24,000 micro-grant program to strengthen digital capacity.

Сэтгүүл зүйн ёс зүйн форум
Journalism Ethics Forum”

Сэтгүүл зүйн ёс зүйн форум 2025”-д 100 гаруй сэтгүүлчид, иргэний нийгмийнхэн оролцож хамтын ажиллагаа, харилцаа холбоог бэхжүүлэв.
More than 100 journalists and civil society representatives participated in the “Journalism Ethics Forum 2025”, strengthening collaboration and networking.

СЭТГҮҮЛ ЗҮЙН ЁС ЗҮЙН ФОРУМ 2026

“Сэтгүүл зүйн ёс зүйн форум” буюу JEF-2026 долоо дахь удаагийн форум есдүгээр сарын 17-нд боллоо. Энэ удаагийн форум “Хиймэл оюун ба сэтгүүл зүйн ёс зүйн эрсдэл” сэдвийн хүрээнд зохион байгуулагдаж хиймэл оюуны хурдтай хөгжлийн сэтгүүл зүйн салбарт үзүүлж буй нөлөө, түүнтэй холбоотой ёс зүйн асуудлаар хэлэлцэв.



Европын Холбоо, Дойче Веллэ Академи, ЮНЕСКО-гийн дэмжлэгтэй зохион байгуулсан тус форумд сэтгүүлчид, хэвлэл мэдээлэл, иргэний нийгэм, технологийн салбарын төлөөлөл, судлаач, багш, оюутнууд оролцож хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт, хиймэл оюуны хэрэглээ, гүн хуурамч агуулга, залруулгын практикийн талаарх илтгэл, судалгааг танилцуулж, оюутны баримт шалгах клубуудын туршлагаас хуваалцав.

Форумын нээлтэд Европын Холбооноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газрын Хамтын ажиллагаа хариуцсан захирал Адриан Мург үг хэлж, ХМЗ-ийн Удирдах зөвлөлийн дарга У.Тамир, Дойче Веллэ Академийн төслийн захирал Килиан Шутце-Алинский, ЮНЕСКО-гийн Зүүн Ази дахь төлөөлөгчийн газрын захирал Шахбаз Хан нар мэндчилгээ дэвшүүллээ. ЮНЕСКО-гийн Зүүн Ази дахь төлөөлөгчийн газрын Харилцаа холбоо, мэдээллийн салбарын хөтөлбөрийн туслах Сюэбинг Ши тус байгууллагын хиймэл оюун болон сэтгүүл зүйн ёс зүйн чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааг танилцуулав.











Хэвлэл мэдээллийн зөвлөлийн Гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа “Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын төлөвшил: Ёс зүйн хорооны шийдвэрийн тойм” сэдвээр илтгэл хэлэлцүүллээ. ХМЗ 2015-2025 онд нийт 651 гомдол хүлээн авч, 409-ийг ёс зүйн хороодоор хэлэлцсэн талаар мэдээлэв. Тэрээр 2025 онд ирсэн гомдлын 80 хувь нь цахим сайтуудад хаяглагдсан бөгөөд мэдээллийг нягтлах, эх сурвалжийн баталгаатай байдлыг хангахтай холбоотой гомдол түгээмэл байгааг дурдсан бөгөөд хиймэл оюунаар боловсруулсан агуулгыг хянан нягтлах, эх сурвалжийн нууцлалыг хамгаалах нь редакцын хүлээх хариуцлагын салшгүй хэсэг болохыг онцоллоо.

Форумын үеэр оюутны баримт шалгах дөрвөн клуб үйл ажиллагаа, туршлагаа танилцуулав. Оттонтэнгэр их сургуулийн CheckPlus клубийн оюутан Э.Өгөдэй, МУБИС-ийн VIBE MNUE клубийн оюутан М.Өсөхбаяр, МУИС-ийн NUM Journalists клубийн оюутан Г.Номин-Эрдэнэ, СУИС-ийн Кино, телевиз, медиа урлагийн сургуулийн CheckLab клубийн оюутан Г.Болор-Эрдэнэ нар мэдээллийн боловсрол, баримт шалгах, сэтгүүл зүйн ёс зүйг хөгжүүлэх чиглэлээр хийж буй ажлаасаа хуваалцлаа.











ЕАБХАБ-ын Хэвлэлийн эрх чөлөөний асуудал эрхэлсэн төлөөлөгч Ян Браату “Хиймэл оюуны эрин үед ёс зүйтэй сэтгүүл зүйг төлөвшүүлэх нь” сэдвээр илтгэл танилцуулав. Мөн МУБИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн доктор Б.Чинзориг “Синтетик медиа буюу гүн хуурамч агуулгын судалгаа”, МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн доктор, дэд профессор Д.Идэржаргал “Монголын онлайн хэвлэл мэдээллийн залруулгын практик” судалгааг тус тус танилцуулж, оролцогчдын асуултад хариулав.











Сэтгүүл зүйн инновац, хөгжлийн “Үүр” төвийн Хөтөлбөр хариуцсан захирал Л.Анударь “Хиймэл оюуны хэрэглээ, боломж, сорилт” илтгэлээр Монголын 20 редакцыг хамарсан судалгааны үр дүнг танилцууллаа. Судалгаанаас харахад редакцууд хиймэл оюуныг давтагддаг ажлыг хөнгөвчлөх, бүтээмж нэмэгдүүлэхэд ашиглах сонирхолтой боловч эрсдэлийн талаарх болгоомжлол хэрэглээг хязгаарлаж байна. Тус төвөөс боловсруулсан “Редакцад хиймэл оюун ашиглах, зохицуулах бодлого” баримт бичгийг мөн танилцуулж, редакцууд өөрсдийн үйл ажиллагаанд нийцүүлэн ашиглах боломжийг хуваалцав.

“Хиймэл оюуны хэрэглээ, боломж, сорилт ба мэдээллийн суурь боловсрол” хэлэлцүүлгийг Сэтгүүл зүйн инновац, хөгжлийн “Үүр” төвийн Хөтөлбөр хариуцсан захирал Л.Анударь чиглүүлж, ФАРО сангийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал А.Бямбажаргал, “Тогтвортой хөгжлийн төлөөх сэтгүүл зүй” ТББ-ын тэргүүн, ХМЗ-ийн ёс зүйн хорооны гишүүн О.Ариунбилэг, Business.mn сэтгүүлийн ерөнхий редактор, ХМЗ-ийн ёс зүйн хорооны гишүүн Г.Даваадорж, “Эгүүр ньюс” агентлагийн программист Боргил нар оролцож хиймэл оюуныг редакцын түвшинд ёс зүйтэй ашиглах туршлага болон сорил боломжуудыг хэлэлцэв. Түүнчлэн редакторын ажлыг хөнгөвчлөх, мэдээлэл боловсруулах хугацааг багасгах туршлага, мэдээллийн нууцлал, аюулгүй байдал болон мэдээллийн суурь боловсролын асуудлыг хөндөв. Оролцогчид хиймэл оюуныг редакцын үйл ажиллагаанд нэвтрүүлэхдээ хүний хяналт, мэргэжлийн ёс зүй, олон нийтийн итгэлийг тэргүүнд тавьж, сэтгүүл зүйн үндсэн зарчмыг тууштай баримтлах шаардлагыг онцолсон юм.

ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГАД ЗОРИУЛСАН ЦАХИМ ОРЧИНД МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХЭД БАРИМТЛАХ ЁС ЗҮЙН ГАРЫН АВЛАГЫГ ТАНИЛЦУУЛЛАА



Технологийн асар хурдацтай хөгжлийн үед мэдээлэл түгээх, хүлээн авах боломж үлэмж нэмэгдэж, түүний нөлөө, ач холбогдол урьд өмнөхөөс ч илүү өсөн нэмэгдсэн. Энэ үйл явцад мэдээллийг дамжуулах платформууд, цаашлаад хиймэл оюуны оролцоо нь боломж ба эрсдэлийг зэрэгцүүлж буй. Энэ нь мэдээлэл боловсруулах, түгээх, ашиглах, мэдээлэлд суурилан бусадтай харилцах бүхий л үйл явцад хувь хүн, байгууллагаас мэдлэг, ур чадвар төдийгүй өндөр түвшний хариуцлага, ёс

зүйг шаардаж байна. Тодруулбал, нийгмийн харилцаанд бодлого тодорхойлох, шийдвэр гаргах үйл явцад голлох үүрэгтэй институцуудын дунд иргэний нийгмийн байгууллагын мэдээлэл, харилцааны ёс зүйн асуудал онцгойлон тавигдах болжээ.

Энэхүү гарын авлага нь мэдээллийн орчинд тулгамдаж буй түгээмэл асуудлуудыг хөндөж, тэдгээрийг даван туулах зөвлөмж, арга зүйг танилцуулах зорилготой. Үүнд, цахим харилцаанд баримтлах ёс зүйн үндсэн зарчим, мэдээллийг хариуцлагатай хэрэглэх, контентыг ёс зүйтэй бүтээх, эмзэг сэдвийг зөв мэдээлэх, хямрал, эрсдэлийн үед баримтлах харилцааны арга барил, мөн шинэ тутам хэрэглээнд нэвтэрч буй хиймэл оюуны технологийн ёс зүйн асуудлуудыг багтаав.

Иргэний нийгмийн байгууллагад зориулсан цахим орчинд мэдээлэл түгээхэд баримтлах ёс зүйн гарын авлагатай энд дарж танилцаарай.

ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГЫН ДИЖИТАЛ ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛАХ БИЧИЛ ТӨСЛҮҮД ХЭРЭГЖИВ

“Өөрчлөлтийн дуу хоолой” төслийн хүрээнд иргэний нийгмийн байгууллагууд цахим технологи, судалгаа, олон нийтийн оролцоонд тулгуурлан хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгарч буй асуудлыг тодорхойлж, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах санаачилгуудыг хэрэгжүүлж байна. Эдгээр бичил төслүүд нь иргэдийн дуу хоолойг хүргэх, бодит хэрэгцээг баримтаар тодорхойлох, шийдвэр гаргагчдад чиглэсэн санал, зөвлөмж боловсруулахад чиглэж байна.

“Тодоос тод од” ТББ хүүхэд, өсвөр үеийнхэнд тулгарч буй үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийлэл, хүүхдийн эрхийн асуудлаар нэрээ нууцлан мэдээлэл өгөх боломжтой “Tod Od” аппликейшнийг хөгжүүлж, 2026 оны наймдугаар сарын 28-нд App Store-д нийтэллээ. Мөн төслийн зорилго, үйл ажиллагаа, аппликейшний талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх tod-od.com цахим сайтыг ашиглалтад оруулав.



Энэхүү цахим шийдэл нь хүүхдүүдэд тулгарч буй асуудлын талаар мэдээлэл цуглуулж, давтагдаж буй хэлбэр, нөхцөлийг тодорхойлоход чиглэж байна. Цуглуулах мэдээллийг дээрэлхэлт, хүчирхийллийн төрөл, тохиолдсон орчин, сэтгэл зүйд үзүүлсэн нөлөө зэрэг үзүүлэлтээр ангилан шинжлэх аргачлалыг бэлтгэжээ. Улмаар судалгааны үр дүнг хүүхэд хамгаалал, боловсролын байгууллага болон сургуулийн төлөөлөлтэй хэлэлцэж, хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлох юм.

Төслийн хүрээнд өсвөр үеийнхэнд зориулан бусдыг ойлгох, эелдэг харилцах, үе тэнгийнхнээ дэмжихийг уриалсан цуврал бүтээл бэлтгэн Facebook, Instagram, TikTok платформоор түгээн хүүхэд, залуучуудад эерэг харилцааны талаар мэдээлэл хүргэлээ.





“Гэрэлт цох байшин” ТББ хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын суралцах эрхийн хэрэгжилт, их сургуулиудын дэмжлэгийн үйлчилгээний талаар судалгаа хийлээ. Судалгаанд албан мэдээлэл, цахим санал асуулга, нүүр тулсан ярилцлага, баримт бичгийн шинжилгээг хослуулан ашиглаж, оюутны хэрэгцээнд нийцсэн сургалтын тохируулга, хүртээмжтэй орчин, мэргэжлийн дэмжлэгийн нөхцөлийг авч үзсэн байна.

Судалгаагаар магадлан итгэмжлэгдсэн 44 их сургуулийн 30-д нь нийт 302 хөгжлийн бэрхшээлтэй оюутан суралцаж байгааг тогтоожээ. Цахим санал асуулгад оролцсон 12 сургууль тодорхой дэмжлэгийн үйлчилгээ үзүүлдэг боловч туслах технологи, хүртээмжтэй сургалтын материал, орчны тохируулгын хэрэгжилт харилцан адилгүй байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй оюутны асуудал хариуцсан тусгай ажилтан цөөн, сургуулиудын бодлого, журам, цахим хуудсанд дэмжлэгийн үйлчилгээний мэдээлэл хангалтгүй байгааг илрүүлжээ.

Үүний зэрэгцээ зарим сургууль сургалтын тохируулга хийх, цахим болон брайл материал бэлтгэх, туслах технологи ашиглах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх сайн туршлагыг хэрэгжүүлж байгааг судалгаанд онцолсон байна. Эдгээр үр дүнд үндэслэн сургуулиудын дотоод бодлого, сургалтын орчин, дэмжлэгийн үйлчилгээг сайжруулах санал, зөвлөмж боловсруулаа..



Сургалтын тохируулгын ач холбогдлыг олон нийтэд таниулах зорилгоор МУИС-ийн хөгжлийн бэрхшээлтэй оюутан, багш, ажилтан, дэмжигч оюутан болон дохионы хэлний хэлмэрчийн оролцоотой дүрс бичлэгийг бэлтгэж, долдугаар сарын 2-нд нийтэллээ. Тус бүтээлээр оюутны хэрэгцээнд нийцсэн дэмжлэгийг сургалтын өдөр тутмын үйл ажиллагаанд хэрхэн хэрэгжүүлж болохыг бодит туршлагаар харуулсан байна. Судалгаа, цахим бүтээлийг цаашид их сургуулиудын хүртээмжтэй боловсролын бодлого, үйлчилгээг сайжруулах нөлөөллийн ажилд ашиглах юм.



“Эмэгтэй удирдагч сан” “Залуусын дуу хоолойн дата шинжилгээ” төслийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 42 дугаар хороо, Баянзүрх дүүргийн 33 дугаар хорооны залуучуудын нийгмийн үйлчилгээний хүртээмж, хэрэгцээг судалж байна. Энэхүү ажил нь залуучуудын бодит туршлага, саналыг цуглуулж, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт болон бусад үйлчилгээг сайжруулах санал боловсруулах зорилготой.





ОЮУТНЫ БАРИМТ НЯГТЛАН ШАЛГАХ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ БОЛОВСРОЛЫН (MIL) КЛУБУУД ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ИДЭВХЖҮҮЛЛЭЭ

МУБИС-ИЙН “VIBE MNUE” КЛУБ

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн “VIBE MNUE” баримт нягтлан шалгах клуб “Өөрчлөлтийн дуу хоолой” төслийн хүрээнд оюутнуудын баримт нягтлах ур чадварыг хөгжүүлэх, орон нутгийн сурагч, багш нарын хэвлэл мэдээллийн боловсролыг дээшлүүлэх сургалт, цахим контентын ажлуудыг үргэлжлүүлж байна.





- Клубийн оюутнууд хуурамч, төөрөгдүүлсэн мэдээллийн төрөл, хиймэл оюунаар дуурайлган бүтээсэн дуу хоолой, хуурамч дүрс бичлэгийг таних талаар богино хэмжээний тайлбар видео бэлтгэн түгээв. Мөн FotoForensics хэрэгслээр зургийг нягтлах, SunCalc ашиглан нарны тусгал, сүүдэрт үндэслэж зураг авсан цаг, байршлыг шалгах, мэдээллийг анхны нөхцлөөс нь салгаж төөрөгдүүлсэн эсэхийг таних аргачлалыг танилцууллаа.

- Орон нутагт чиглэсэн үйл ажиллагааны хүрээнд тавдугаар сарын 7–9-нд Хэнтий аймгийн Хэрлэн сумын ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургуулийн ахлах ангийн 120 сурагч, 12 багшийг хамруулсан сургалт зохион байгууллаа. Сурагчдад цахим орчны зохистой хэрэглээ, хувийн мэдээллээ хэрхэн хамгаалах, мэргэжил сонголтын талаар мэдээлэл өгч, багш нарт орчин үеийн технологи, хиймэл оюуныг сургалтад ашиглах болон хичээл заах арга зүйн сургалт явуулав.





- Зургаадугаар сард клубийн гишүүд худал, төөрөгдүүлсэн мэдээлэл нийгэм, эдийн засагт учруулах хор уршгийг шинжлэх дотоод сургалтад хамрагдав.

- Түүнчлэн баримт нягтлах цахим сайтын үндсэн бүтэц, цэсийг боловсруулж, хөгжүүлэлтийн бэлтгэлийг хангасан бөгөөд сайтыг ашиглалтад оруулах, баталгаажуулсан мэдээлэл болон сургалтын материалыг тогтмол нийтлэхээр төлөвлөж байна.

ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛИЙН “CHECK-PLUS” КЛУБ

Отгонтэнгэр их сургуулийн “CheckPlus” баримт нягтлан шалгах клуб төслийн хүрээнд подкаст бэлтгэн олон нийтэд хүргэж байна.



YOUTUBE.COM
"Check Plus" Podcast Guest: Бизнес Эрхлэгч Э. Энхтамир (EP 5)



- Энэхүү подкастаар эрүүл мэнд, сэтгүүл зүй, боловсрол, эдийн засаг зэрэг сэдвээр нийт таван дугаар бэлтгэн YouTube болон Facebook сувгаар түгээгээд байна. Подкастад хэвлэлийн эрх чөлөө, сэтгүүлчийн үүрэг хариуцлага, залуучуудын хөгжил, боловсролын үнэ цэнэ, хоол тэжээлийн талаар болон санхүүгийн удирдлагад гаргадаг түгээмэл алдаа, санхүүгийн сахилга бат гэх мэтчилэн өргөн хүрээний сэдвийг хамруулан оюутан залуучууд, олон нийтэд тогтмол мэдээлэл хүргэж байна.

- Түүнчлэн баримт нягтлах мэдлэг, арга зүйг сургалтын үйл ажиллагаанд тогтвортой нэвтрүүлэх зорилгоор сэтгүүл зүйн бакалавр, магистрын хөтөлбөрийг шинэчлэв. Энэ хүрээнд “Баримт нягтлах арга зүй” гурван багц цагийн хичээлийн хөтөлбөрийг боловсруулж, сургалтын хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлэхээр бэлтгэжээ. Батлагдсаны дараа тус хичээлийг сургалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

- Клуб цаашид подкастын дугааруудаа тогтмол бэлтгэн, шинэ гишүүдийг элсүүлэх, мэргэжлийн сэтгүүлч, баримт нягтлагчдыг урьж сургалт зохион байгуулах зэргээр үйл ажиллагаагаа идэвхжүүлэн ажиллаж байна. Төслийн үйл ажиллагаа 10-р сарын 30 хүртэл үргэлжилнэ.

МУИС-ИЙН “NUM JOURNALISTS” КЛУБ

Монгол Улсын Их Сургуулийн “NUMJournalists”баримтнягтлан шалгах клуб “Өөрчлөлтийн дуу хоолой” төслийн хүрээнд сэтгүүл зүйн үүрэг, хариуцлагыг таниулах, мэдээллийг нягтлах дадлыг дэмжих, оюутнуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор таван чиглэлийн цуврал бүтээл бэлтгэн түгээлээ. Цуврал бүр ярилцлага, тайлбар видео, баримт нягталсан мэдээлэл, мэдээний хөтөлбөр болон хошин өгүүлэмж гэсэн өөрийн онцлог хэлбэрээр үзэгчдэд хүрч байна.









- “Сэтгүүлзүйнтухайярилцъя” цуврал нь оюутнуудыг мэргэжлийн сэтгүүлчидтэй уулзуулж, салбарын туршлага, мэргэжлийн үнэ цэн, хариуцлагын талаар нээлттэй ярилцах боломжийг бүрдүүллээ.. “News Cafe”-д болсон уулзалтад 18 оюутан оролцсон бөгөөд ярилцлагаас бэлтгэсэн хоёр богино видео нийт 949 үзэлт авчээ.

- “Сэтгүүл зүйн ABC” цувралаар сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны үндсэн ойлголтыг богино, энгийн тайлбар видеогоор таниулахыг зорьжээ. Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг тохиолдуулсан“Сэтгүүлзүйн ёс зүй ба хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт” хэлэлцүүлэгтэй холбоотой мэдээлэл, богино видео бэлтгэн түгээж, нийт 1,000 орчим үзэлт авсан байна.

- “Баримтаар нотлогдсон” цуврал нь цахим орчинд түгсэн мэдээллийг нягталж, шалгасан үр дүнг олон нийтэд ойлгомжтой хүргэхэд чиглэлээ. Энэ хүрээнд гэрэлтэй унтах нь жин нэмэхэд нөлөөлдөг эсэх тухай мэдээллийг нягталсан богино видео бэлтгэжээ.

- “NUM Weekly News” хөтөлбөрөөр их сургуулийн онцлох үйл явдал, оюутнуудад хамаарах мэдээллийг нэгтгэн дүрс бичлэгээр хүргэж байна. Клубийн мэдээллийг их сургуулийн хамт олон тогтмол хүлээн авч, зарим нэгж үйл ажиллагаагаа сурвалжлуулах хүсэлт ирүүлэх болсон байна.

- “NUM Maaz” цуврал нь оюутан залуусын эрх, үүрэг, өдөр тутмын амьдрал, нийгмийн асуудлыг хошин хэлбэрээр хөндөж, хариуцлагатай оролцоонд уриалсан нь онцлог байв. Хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулахыг уриалсан богино видео нь 56,800 үзэлт авч, 65 удаа хуваалцсан бөгөөд оюутнуудын бүтээл цахим орчинд түгэхийн зэрэгцээ бүтээлч шийдэл, агуулгаараа олон нийтийн анхаарлыг татсаар байна.

СУИС-ИЙН “CHECKLAB” КЛУБ

Соёл урлагийн их сургуулийн Кино, телевиз, медиа урлагийн сургуулийн “CheckLab” баримт нягтлан шалгах клуб оюутнуудын бүтээлд тулгуурласан 7 хоног тутмын сонинг бэлтгэн олон нийтэд хүргэлээ.





- Эхний дугаарт баримт нягтлах арга зүй, сэтгүүл зүйн ёс зүй, худал мэдээлэл, хиймэл оюунаар бүтээсэн хуурамч мэдээлэл, цахим залилангийн талаар нийтлэл, ярилцлага, тайлбар, инфографик зэргийг багтаан оюутан залуус, олон нийтэд мэдээлэл хүргэж байна.



- Тавдугаар сарын 1-нд парламентын мэтгэлцээний тэмцээн зохион байгуулж, оюутнууд сэтгүүл зүйн сэдвээр баримтад тулгуурлан байр суурия илэрхийлэх, үндэслэл дэвшүүлэх, мэдээлэлд дүн шинжилгээ хийх чадвараа сорив.

- Түүнчлэн “CL Guest Speaker Series” цуврал уулзалтуудыг зохион байгуулж буй бөгөөд төгсөх ангийн оюутан М.Чинбилэг Монголын болон гадаадын мэдээллийн сайтуудын хиймэл оюуны хэрэглээний талаарх судалгаагаа танилцуулж, хиймэл оюунаар бүтээсэн зургийг таних шалгуурын талаар хэлэлцүүлэг өрнүүллээ.
- Клуб шинэ хичээлийн жилд гишүүнчлэлээ нэмэгдүүлж, сургалт, менторшип уулзалт болон контент бүтээх ажлаа үргэлжлүүлэхээр төлөвлөж байна.

Хэвлэл мэдээллийн ярилцлага, нийтлэлээс:

- “Зууны мэдээ” сонины 2025 оны 9-р сарын 22-ны дугаар, “Д.Тэгшбаяр: Төрөөс платформ гаргаж, Иргэний нийгмийн байгууллагууд мэдээллээ оруулдаг байх нь зөв” ярилцлага
- “ikon.mn” сайт, 2025 оны 10-р сарын 7, “Г.Гүнжидмаа: Зөвхөн сэтгүүлчид ч биш, бүгдээрээ ёс зүйн хариуцлагаа ухамсарлаж, AI эринийг зөв угтах ёстой” ярилцлага
- “gogo.mn” сайт, 2025 оны 10-р сарын 9, “С.Бадрал: AI нөлөө нь чадварлаг, бүтээлч хүмүүст улам үнэлэгдэж, хүчтэй болох боломж олгож байна” ярилцлага
- “gogo.mn” сайт, 2025 оны 10-р сарын 13, “Сэтгүүл зүйн ёс зүйн форум 2025: Ирээдүйд хиймэл оюун ухаан сэтгүүлчийг орлох уу?”
- “Зууны мэдээ” сонины 2026 оны 1-р сарын 05-ны дугаар, “Ц.Сувданцэцэг: Нийгмийн хөгжилд иргэний нийгмийн байгууллагуудын дуу хоолой чухал үүрэгтэй” ярилцлага
- peak.mn, 2026 оны 1-р сарын 28, Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх иргэний нийгмийн чуулган болно
- movement.mn, 2026 оны 1-р сарын 29, “Төр, иргэний нийгмийн түншлэлийг бэхжүүлье” иргэний нийгмийн чуулган маргааш болно.
- uih.mn, 2026 оны 1-р сарын 30, Иргэний нийгмийн байгууллагуудын чуулган боллоо
- “Зууны мэдээ” сонины 2026 оны 2-р сарын 04-ны № 23 (7765) дугаар, Тэрсэлддэг биш түншилдэг төр-иргэний нийгмийн төлөө...
- time.mn, 2026 оны 2-р сарын 04, Д.Тэгшбаяр: Би АН-ын гишүүн байсан бол төрийн өмчийн компаниудад зориулсан хуулийг эсэргүүцэх байсан
- gogo.mn, 2026 оны 2-р сарын 03, Иргэний нийгмийнхэн: “Биднийг бүү дээрээс хар, хамтарч ажиллая”
- gogo.mn, 2026 оны 2-р сарын 12, Иргэний нийгмийн чуулганы мөрөөр Монгол Улсын Ерөнхийлөгчид хүсэлт хүргүүллээ
- uih.mn, 2026 оны 2-р сарын 13, “Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичиг боловсруулжээ
- peak.mn, 2026 оны 2-р сарын 26, Иргэний нийгмийн байгууллагууд Ерөнхийлөгчид хүсэлт хүргүүллээ
- “Зууны мэдээ” сонины 2026 оны 4-р сарын 01-ний № 61 (7803) дугаар, “VIBE MNUE” баримт шалгагч оюутан клуб нээгдлээ
- news.edu.mn, 2026 оны 4-р сарын 14, “Хэвлэл мэдээлэлд бидний оролцоо” парламентын мэтгэлцээний тэмцээний аваргууд тодорлоо
- “VIBE MNUE” клубын сошиал медиа сувгууд
- “VIBE MNUE” Fact-Checking Students (Facebook хуудас)
- Vibefactcheckingclub (Instagram)
- “CheckPlus” клубын сошиал медиа сувгууд
- CheckPlus Student Club (Facebook хуудас)
- CheckPlus @CheckPlusStudentClub (YouTube)
- “NUM ” клубын сошиал медиа сувгууд
- NUM Journalists (Facebook хуудас)
- num_journalists_club (Instagram)
- https://num-journalist.com/ (Website)
- “CheckLab ” клубын сошиал медиа сувгууд
- MNUAC SBMA Student Fact Checking Club (Facebook хуудас)

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Өөрчлөлтийн дуу хоолой: Иргэний нийгмийн байгууллагууд эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн ойлголтын төлөө хүчээ нэгтгэх нь” төслийг Европын Холбооны дэмжлэгтэйгээр Хэвлэл мэдээллийн зөвлөл, Дойче Велле Академи хамтран хэрэгжүүлж байна.

Санхүүжүүлэгч: Европын Холбоо
Хэрэгжүүлэгч: Монголын Хэвлэл Мэдээллийн Зөвлөл, ХБНГУ-ын Дойче Велле Академи
Хэрэгжих хугацаа: 2023-2026 он

Төслийн зорилго

Иргэний нийгмийн байгууллагуудын хариуцлагатай, ил тод, бие даасан байдлыг дэмжиж, иргэний нийгмийн үйл ажиллагааны талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх замаар сайн засаглал, нийгмийн эв нэгдэлд хувь нэмрээ оруулахад чиглэнэ.

ЗОРИЛТ 1. ИНБ-уудын засаглал, цахим орчинд ажил хэргээ эрхлэх, үйл ажиллагаа явуулах чадавх сайжирч, “Хариуцлагатай иргэний нийгэм”-ийн удирдамжийг бий болгосон байна.
ЗОРИЛТ 2. Төр, иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээллийнхэн иргэдийн оролцоог дэмжих эрх зүйн болон бодлогын таатай орчныг бүрдүүлэх талаар харилцан ойлголцлоо нэмэгдүүлнэ.
ЗОРИЛТ 3. ИНБ, хэвлэл мэдээлэл хамтран бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэх, нөлөөллийн үйл ажиллагаа явуулахдаа залуучууд, нийгмийн бусад бүлгийг идэвхтэй оролцуулах цахим харилцааны шинэ хэлбэрийг дэмжинэ.

Зорилтот бүлгүүд

- ИНБ: Иргэний нийгмийн салбарын хот, хөдөөгийн нийт 500 ажилтан – үүний 50% нь залуучуудтай ажилладаг
- Залуучууд: 16–35 насны 800 залуу – 50% нь эмэгтэй.
- Хэвлэл мэдээлэл: Хот, хөдөөгийн хэвлэл мэдээллийн байгууллагад ажилладаг 500 ажилтан (сэтгүүлч, редактор гэх мэт) – 50% нь эмэгтэй.
- Төрийн төлөөлөгчид: Хот, хөдөөгийн 100 улс төрийн болон төрийн албан хаагч – иргэний нийгмийн асуудалд сонирхолтой, өөрчлөлт авчрах чадамжтай бүлэг.

Хэвлэл Мэдээллийн Зөвлөл (ХМЗ) нь сэтгүүлч, ажил олгогч, салбарын эвсэл холбоод, мэргэжлийн байгууллагуудын санаачилга, амжилттай хамтын ажиллагааны үр дүнд анхлан байгуулагдаж, үйл ажиллагаагаа хэрэгжүүлээд даруй 10 дахь жилдээ орж буй НҮТББ билээ. Энэ хугацаанд Хэвлэл Мэдээллийн Зөвлөл нь хэвлэл мэдээллийн байгууллагуудын хариуцлагыг сайжруулах, сэтгүүл зүйн ёс зүй болон мэргэжлийн стандартыг хөгжүүлэх зэрэг үйл ажиллагааны үндсэн чиглэлийнхээ хүрээнд олон нийтээс ирүүлсэн 600 гаруй гомдлыг хүлээн авч, хэлэлцэн шийдвэрлээд байна. Улмаар хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсад өөрсдийн бий болгосон ёс зүйн зарчмаа дагаж мөрддөг, салбарын өөрийн зохицуулалтын механизмыг амжилттай бий болгоод байна.

Монгол Улсад хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтыг хөгжүүлэн бэхжүүлж буй туршлага болон хэвлэл мэдээлэл - төр - иргэний нийгмийн хөгжлийн төлөөх хамтын түншлэл, харилцаа холбоог бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанууд нь хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн эгэх хариуцлагыг хөндөх “Өөрчлөлтийн дуу хоолой: Иргэний нийгмийн байгууллагууд эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн ойлголтын төлөө хүчээ нэгтгэх нь” төслийг хэрэгжүүлэх үндэс суурь болсон юм.

Гурван жилийн хугацаатай хэрэгжих уг төслийг Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр Хэвлэл Мэдээллийн Зөвлөл, ХБНГУ-ын Дойче Велле Академи хамтран хэрэгжүүлэх бөгөөд иргэний нийгмийн байгууллагуудын хариуцлагатай, ил тод, бие даасан байдлыг дэмжиж, иргэний нийгмийн үйл ажиллагааны талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх замаар сайн засаглал, нийгмийн эв нэгдэлд хувь нэмрээ оруулах юм.

Хэвлэл Мэдээллийн Зөвлөлөөс ХБНГУ-ын Дойче Велле Академи (DWA)-тай хамтран Европын Холбооны дэмжлэгтэйгээр “Өөрчлөлтийн дуу хоолой: Иргэний нийгмийн байгууллагууд эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн ойлголтын төлөө хүчээ нэгтгэх нь” төслийг 2023-2026 онд хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд иргэний нийгмийн байгууллагуудын ил тод, бие даасан байдлыг дэмжиж, иргэний нийгмийн үйл ажиллагааны талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх замаар сайн засаглал, нийгмийн эв нэгдэлд хувь нэмрээ оруулах үндсэн зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Төслийн хоёрдугаар үе шат нь иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээлэл, залуучууд зэрэг нийгмийн олон талт бусад бүлгүүдийг төрийн бодлогын хэлэлцүүлэгт татан оролцуулах эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэж буй юм.

Энэхүү цахим мэдээллийн товхимлыг төслийн үйл ажиллагааг
таниулан сурталчлах зорилгоор бэлтгэв.

“Өөрчлөлтийн дуу хоолой” төсөл
Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
43-р хороо, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж,
Юу Би тауэр, 18-р давхар, #1803
Утас: (976) 7000 0160
Имэйл: info@mediacouncil.mn

ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОН ЗАЙГ БЭХЖҮҮЛЭХ ҮЙЛСИЙГ ДЭМЖИГЧ ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА.